



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 08 сарын 24 өдөр

Дугаар 324

Улаанбаатар хот

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол улсын “Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, Эрүүл мэндийн Сайдын 2008 оны 212 дугаар тушаалаар батлагдсан “Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүн, угж түүнтэй адилтгах зүйлийн чанар, аюулгүй байдлыг хангах, тэдгээрт хяналт тавих журам”-ын 3.2.1. дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний импорт, худалдаа, хэрэглээг судлах судалгааг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, судалгааны удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний импорт, худалдаа, хэрэглээг судлах судалгааг 2015 оны дөрөвдүгээр улиралд багтаан дуусгахыг ажлын хэсгийн ахлагч (Э. Оюунсүрэн)-д үүрэг болгосугай.
3. Судалгааны үр дүнг “Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад тусгаж ажиллахыг Стратегийн бодлого төлөвлөлтийн газар /Р.Оюунханд/, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Баяр/-т даалгасугай.

САЙД



Г. ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

081141

Эрүүл мэнд, спортын сайдын 2015
оны 08 дугаар сарын 27 өдрийн 324
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний импорт, худалдаа, хэрэглээг
судлах судалгааг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн**

Ажлын хэсгийн ахлагч:

Э. Оюунсүрэн, ЭМСЯ-ны Хяналт-шинжилгээ,
үнэлгээ, дотоод аудитын газрын дарга,

Нарийн бичгийн дарга:

Н.Цогзолмаа, ЭМСЯ-ны Хяналт-шинжилгээ,
үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн,

Гишүүд:

Д.Ганзориг, ЭМСЯ-ны Эрүүл мэндийн бодлогын
хэрэгжилтийг зохицуулах газрын Нийгмийн эрүүл
мэндийн хэлтсийн мэргэжилтэн,

С.Гончигсумлаа, ЭМСЯ-ны Стратегийн бодлого
төлөвлөлтийн газрын мэргэжилтэн,

Б. Цогтбаатар, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн
захирал,

Ж.Батжаргал, НЭМХ-ийн Хоол судлалын төвийн дарга,

Д.Энхмягмар, НЭМХ-гийн Хоол судлалын төвийн
эрдэм шинжилгээний дадлагажигч ажилтан,

Т.Төмөрбаатар, МХЕГ-ын Хилийн мэргэжлийн хяналтын
хэлтсийн Хил, гүний гааль хариуцсан улсын ахлах
байцаагч /зөвшилцсөнөөр/,

Ч.Гантулга, МХЕГ-ын Эрүүл мэнд, боловсрол, соёл,
шинжлэх ухааны хяналтын хэлтсийн Эрүүл ахуй,
халдварт хамгааллын улсын ахлах байцаагч
/зөвшилцсөнөөр/,

Н.Нарантуяа, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын
Экспорт, импортын асуудал хариуцсан улсын байцаагч
/зөвшилцсөнөөр/,

Б. Даваадулам, ХХААЯ-ны Хүнсний үйлдвэрийн
бодлогын хэрэгжилт зохицуулах газрын мэргэжилтэн
/зөвшилцсөнөөр/,

Ш. Цолモン, ХЗЯ-ны Хууль зүйн нэгдсэн бодлогын газрын
Хөдөлмөрийн болон хүн ам, нийгмийн хамгааллын
салбарын хууль тогтоомж хариуцсан ахлах мэргэжилтэн
/зөвшилцсөнөөр/,

Л. Мөнхжаргал, НҮБ-ийн Хүүхдийн сангийн хоол
тэжээлийн хөтөлбөрийн мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/,

Эрүүл мэнд, спортын сайдын 2015
оны 08 дугаар сарын 22-өдрийн 324
дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт

Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний импорт, худалдаа, хэрэглээг судлах судалгааны удирдамж

Үндэслэл

Хүүхдийг эхийн сүүгээр хооллохыг дэлхий даяар дэмжин, хамгаалах зорилгоор Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сан хамтран 1981 онд “Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний маркетингийн олон улсын хууль”-ийг баталсан. Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүн (ЭСОБ)-ий импорт, худалдаа нь Монгол улсад “Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний тухай хууль” (2005), “ЭСОБ, угж түүнтэй адилтгах зүйлийн чанар, аюулгүй байдлыг хангах, тэдгээрт хяналт тавих журам” (ЭМС-ын 2008 оны 212 дугаар тушаал)-аар зохицуулагдаг боловч хяналт-шинжилгээ, үнэлгээ тогтмол хийгдэхгүй, импорт нь жил ирэх тутам нэмэгдэж байна. Тухайлбал, 2012 онд 26.8 тн, 2013 онд 103.0 тн, 240.3 тн ЭСОБ импортоор орж ирсэн (МХЕГ-ын XMXX-ийн мэдээ, 2015). Цөөн тооны эхчүүдэд хийсэн судалгаагаар 30.9% нь эрүүл мэндийн ажилтнаас бүтээгдэхүүнийг хэрэглэх зөвлөгөө авсан, 28.5% нь ЭСОБ-ийг үнэгүй бэлгэнд авсан, мөн зах зээлд худалдаалж буй ЭСОБ-ний дийлэнх нь шошгын зөрчилтэй байсан (ЭМЯ, Монгол Улс дахь “Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний тухай хууль”-ийн хэрэгжилт, мониторингийн тайлан, 2012) байна.

Монгол улсын хүүхдийг эхийн сүүгээр хооллох үзүүлэлтүүд жил ирэх тусам буурсаар байна. Тухайлбал, 2010 онд нийт нялхсын 66 хувь нь төрснөөс хойш эхний 6 сарын турш эхийн сүүгээр дагнан хооллож байсан бол 2013 онд уг үзүүлэлт 47.1 хувь хүртэл буурсан байна (YCХ, 2013). Энэхүү бууралт нь эхийн сүү орлуулагч сүүн тэжээлийн импорт, зар сурталчилгаа нэмэгдсэн, эхийн сүүгээр хооллолтын дэмжих бодлогын хэрэгжилт хангалтгүй, эхчүүд хүүхдээ төрүүлсний дараа богино хугацаанд ажилдаа эргэн орох зэрэг олон шалтгаантай байна. Иймд “Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний тухай” хууль, холбогдох журмын хэрэгжилтийг үнэлэх, “Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний тухай” Монгол Улсын хуулийг шинэчлэн боловсруулахад шаардлагатай мэдээллийг цуглуулах, ЭСОБ-ний импорт, худалдаа, хэрэглээний өнөөгийн байдлыг судалж, дүн шинжилгээ хийх шаардлагатай байна.

Зорилго

Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүн, угж түүнтэй адилтгах зүйлийн импорт, худалдаа, зар сурталчилгаа, хэрэглээг судлах судалгааг зохион байгуулж, үр дүнг “Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний тухай” хуулийн шинэчилсэн найруулгийн төсөлд тусгах

Зорилт

1. Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүн, угж түүнтэй адилтгах зүйлийн импорт, худалдаа, зар сурталчилгаа, хэрэглээг судлах судлаачдын багийг бүрдүүлэх, судалгааны бэлтгэл ажлыг зохион байгуулах,
2. Судалгааны үр дүнг хэлэлцэн дүн шинжилгээ хийж, Засгийн газрын байгууллагуудад хүргүүлэх,
3. Судалгаанаас гарсан үр дүн, баримт нотолгоог хуулийн шинэчилсэн найруулгийн төсөлд тусгах

Судалгааг дараах хүрээнд зохион байгуулна. Үүнд:

1. ЭСОБ-ний импорт, худалдаа, чанар аюулгүй байдлын баталгаажилтыг судлах,
2. ЭСОБ, угж түүнтэй адилтгах зүйлийн зар сурталчилгааны талаар мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийх,
3. Эрүүл мэндийн байгууллагаас хүүхдийг эхийн сүүгээр хооллох талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагааг үнэлэх,
4. ЭСОБ, угж түүнтэй адилтгах зүйлийн хэрэглээг судлах.

Судалгааны чиглэл

Судалгаанд Улаанбаатар хотын Баянгол, Сонгинохайрхан дүүрэг, Сэлэнгэ аймгийн Мандал, Сайхан сум, Дорнод аймгийн Чойбалсан, Баян-Уул сууас сонгогдсон эрүүл мэндийн байгууллага (Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн төв, амаржих газар, хувийн хэвшлийн хүүхдийн эмнэлэг тус бүр 2), ЭСОБ импортлогч томоохон аж ахуйн нэгж, ЭСОБ-ийг худалдан борлуулдаг аж ахуйн нэгж, байгууллага (худалдааны төв, зах, супермаркет, хүнсний дэлгүүр, эмийн бөөний худалдааны төв, эмийн сан тус бүр 2), 6 хүртэлх сартай хүүхэдтэй эхчүүд хамрагдана. Судалгааны мэдээллийг дараах чиглэлээр цуглуулна. Үүнд:

а) Эрүүл мэндийн байгууллага: Эмнэлгийн удирдлага, эрүүл мэндийн ажилтнуудтай хийх ярилцлага:

- Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих үйл ажиллагаа, үр дүн
- Эх, хүүхдэд ээлтэй эмнэлгийн үйл ажиллагаа
- ЭСОБ-ний тухай ойлголт, хандлага
- ЭСОБ-ний тухай хууль, журамын талаарх ойлголт, хандлага
- Зар сурталчилгаатай холбоотой мэдээлэл

б) ЭСОБ импортлогч аж ахуйн нэгжээс цуглуулах мэдээлэл:

- ЭСОБ-ний импортоор оруулж ирсэн хэмжээ, нэр төрөл
- ЭСОБ-ний чанар, аюулгүй байдлын баталгаажилт
- ЭСОБ-ний тухай хуулийн талаарх ойлголт, хандлага
- ЭСОБ, угж түүнтэй адилтгах зүйлийн чанар, аюулгүй байдлыг хангах, тэдгээрт хяналт тавих журмын талаарх ойлголт, хандлага

в) Худалдааны байгууллагаас цуглуулах мэдээлэл:

- ЭСОБ-ний хаяглалт, шошгололт, сурталчилгаа
- ЭСОБ -ний тухай ойлголт, хандлага, хандлага
- ЭСОБ-ний тухай хуулийн талаарх ойлголт, хандлага
- ЭСОБ, угж түүнтэй адилтгах зүйлийн чанар, аюулгүй байдлыг хангах, тэдгээрт хяналт тавих журмын талаарх ойлголт, хандлага

г) 6 хүртэлх сартай хүүхэдтэй эхчүүдтэй хийх ярилцлага:

- Хүүхдийн эхийн сүүгээр хооллох тухай ойлголт
- ЭСОБ-ний талаарх ойлголт, хандлага хэрэглэх болсон шалтгаан

д) Хэвлэл мэдээллийн хэрэгсэл:

- ЭСОБ-ийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр сурталчилсан байдал (интернет, ТВ, радио, утас, бусад сонин сэтгүүл).

Судалгааны үр дүн

1. ЭСОБ, угж түүнтэй адилтгах зүйлийн импорт, худалдаа, зар сурталчилгаа, хэрэглээний өнөөгийн байдал (Судалгааны тайлан),
2. ЭСОБ-ний тухай хуулийн шинэчилсэн найруулагын үзэл баримтлал, төсөлд тусгах санал, зөвлөмж,
3. ЭСОБ, угж түүнтэй адилтгах зүйлийн импорт, худалдаанд тавих хяналтыг сайжруулах санал, зөвлөмж,

Хэрэгжүүлэгч байгууллага: ЭМСЯ, НЭМХ, МХЕГ

Хугацаа: 2015 оны 9 - 12 сар

Санхүүжүүлэгч байгууллага: НҮБ-ын Хүүхдийн сан

Санхүүжилт: 10 000 \$

Гарах үр дүн: Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүн, угж түүнтэй адилтгах зүйлийн импорт, худалдаа, зар сурталчилгаа, хэрэглээний өнөөгийн байдлыг цогцоор үнэлж хуулийн шинэчилсэн найруулагт тусгахад чиглэл болно.

---oOo---

Судалгааны ажлын төлөвлөгөө

Д/д	Гүйцэтгэх ажил	Хариуцах байгууллага, албан тушаалтан	Хугацаа (сар)
1.	Судалгааг хамтран зохион байгуулах саналыг холбогдох байгууллагад тавих	Ж. Батжаргал, НЭМХ-гийн ХСТ	VII сар
2.	Судалгааны ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг тушаалаар томилуулах, судалгааны удирдамжийг батлуулах	Ж. Батжаргал, Д. Энхмягмар, НЭМХ-гийн ХСТ	VIII сар
3.	Судалгааны аргачлал боловсруулах, батлуулах	Ж. Батжаргал, Д. Энхмягмар, НЭМХ-гийн ХСТ	VIII сар
4.	Судалгааны төсөв боловсруулж, батлуулах	Д. Энхмягмар, НЭМХ-гийн ХСТ	VIII сар
5.	Судалгааны аргачлалыг ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэх	Ж. Батжаргал, Д. Энхмягмар, НЭМХ-гийн ХСТ	VIII сар
6.	Судалгааны аргачлалыг НЭМХ-гийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулах		IX сар
7.	Судалгааны аргачлалыг ЭМСЯ-ны дэргэдэх Ёс зүйн хяналтын хороогоор хэлэлцүүлэн, судалгаа хийх зөвшөөрөл авах		IX сар
8.	Судалгааны мэдээлэл цуглуулах ажлын бэлтгэл хангах	Д. Энхмягмар, З. Цолмон НЭМХ-гийн ХСТ	IX сар
9.	Судалгааны арга зүйн сургалтыг зохион байгуулах		IX сар
10.	УБ хотод судалгааны мэдээлэл цуглуулах	Судалгааны баг	IX сар
11.	Сэлэнгэ аймагт судалгааны мэдээлэл цуглуулах		X сар
12.	Дорнод аймагт судалгааны мэдээлэл цуглуулах		X сар
13.	Судалгааны мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх		X сар
14.	Судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийх		X сар
15.	Судалгааны тайлан бичих, хянах		X – XI сар
16.	Судалгааны тайланг англи хэлрүү орчуулах, хянах		XI – XII сар
17.	Тайлангийн хэвлэлийн эхийг бэлтгэх	З. Цолмон, НЭМХ-гийн ХСТ	XII сар
18.	Судалгааны үр дүнг танилцуулах уулзалт зохион байгуулах	Ж. Батжаргал, НЭМХ-гийн ХСТ	XII сар
19.	Судалгааны санхүү болон үйл ажиллагааны тайлан (ЭМСЯ, НҮБХС-д)	Д. Энхмягмар, НЭМХ-гийн ХСТ	XII сар